



*ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу Хэнтий аймгийн Аудитын
газрын 2016 онд хийсэн гүйцэтгэлийн аудит*

**УЛСЫН НӨӨЦИЙН ХУДАЛДАН АВАЛТЫГ ХУУЛИЙН
ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖ, СТАНДАРТЫН
ШААРДЛАГА ХАНГАСАН БАРАА МАТЕРИАЛААР
БҮРДҮҮЛСЭН БАЙНА**

Аудитын код: **ҮАГ-ГАГ/2016/05-ГА-ХЭ**

Аудитын нэр: “Улсын нөөцийн бүрдүүлэлт,
хуваарилалт, зарцуулалт, үр дүн”

Чингис хот

2016 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
ГА	Гүйцэтгэлийн аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ХБУ	Хэрлэн баян улаан
УНХТГ	Улсын нөөцийн хүмүүнлэгийн тусламжийн газар
УНС	Улсын нөөцийн салбар

Тайлан бэлтгэгсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн аудитын газар	АГУУЛГА	
	Ерөнхий зүйл	4-6
Хэнтий аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин	Нэг. Улсын нөөцийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, стандартын шаардлага хангасан бараа материалаар бүрдүүлсэн байна.	7-8
	1.1 Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	7
Аудитын менежер: Б.Наранцэцэг	1.2 Улсын нөөцийн бараа материалыг шинжилгээнд бүрэн хамруулж мэргэжлийн хяналтын дүгнэлт гаргуулсан байна.	8
Ахлах аудитор: Н.Туяа	Хоёр. Улсын нөөцийн барааны зарцуулалтын зориулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	9-10
Аудитор: Ц.Хатанболд		
2016 оны 05 дугаар сар	2.1. Нөөцийн барааг эрх бүрий байгууллагын шийдвэрийн дагуу зарцуулсан боловч зориулалт тодорхойгүй байна.	9
	2.2. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	9-10
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу	Гурав. Улсын нөөцөд тавих дотоод хяналт үр дүнгүй байна.	11
	3.1 Улсын нөөцөд тавих дотоодын хяналтын тогтолцоо бүрдсэн байна.	11
	3.2 Улсын нөөцөд тавих дотоодын хяналтыг үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна.	11
	3.3 Дотоод хяналтаар илрүүлсэн алдаа зөрчлийн талаар ямар нэгэн баримт байхгүй байна	11
Хаяг: Хэнтий аймаг, Чингис хот, АЗДТГ- ын байр 325 тоот өрөө	Дөрөв. Дүгнэлт	12
	Тав. Аудитын зөвлөмж	13
	Зургаа. Холбогдох байгууллагын санал	14
	Долоо. Хавсралтууд	14

Ерөнхий зүйл

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.14 заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд Хэнтий аймгийн Аудитын газар гүйцэтгэлийн аудит хийв.

2. Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, үр дүнтэй эсэхийг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:.

- *Улсын нөөцийг арвилан хэмнэлттэйгээр, стандартын шаардлага хангасан бараа материалаар бүрдүүлсэн эсэх*
- *Улсын нөөцийн барааг бүртгэж, зориулалтын дагуу хуваарилж үр дүнтэй зарцуулсан эсэх*
- *Улсын нөөцөд тавих дотоод хяналт үр нөлөөтэй эсэх*

Аудитад Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хэнтий аймгийн Улсын нөөцийн салбар болон Өмнөдэлгэр сумын Хурх, Дэлгэрхаан сумын Хэрлэн баян улаан, Батноров сумын Бэрх тосгонд байрлах улсын нөөцийн бараа материалын хадгалалтын цэгийн 2015 оны үйл ажиллагаа хамрагдлаа.

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 5510-5520 стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, судалгаа тодруулга авч, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, зарим арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах, аймгийн хэмжээн дэх Улсын нөөцийн 3-н цэгт очиж биет тооллого хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

3. Шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны талаархи товч мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хэнтий аймгийн Улсын нөөцийн салбар нь Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, болзошгүй гэнэтийн аюул, байгаль цаг уурын бэрхшээл, эдийн засгийн хүндрэл тохиолдсон нөхцөлд хэрэглэх зориулалт бүхий улсын нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил Хэрлэн баян улаан, Хурх, Бэрх тосгонуудад, нэр төрөл, тоо хэмжээнд нь хүргэн бүрдүүлэх, хадгалалт, хамгаалалт, сэлгэлт, шинэчлэлт, тээвэрлэлт, зарцуулалт хийх ажлуудыг зохион байгуулж байна.

**НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ**

- **Улсын нөөцийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, стандартын шаардлага хангасан бараа материалаар бүрдүүлсэн байна.**

1.1 Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

1.1.1 Хэнтий аймгийн УНС-т 2015 онд нийт 309 тн үрийн будаа, 207,9 тн өвс, 250 тн хивэг бэлтгэсэн байна.

- A. ОБЕГ-ын нөөцийн 03 салбараас ХБУ-ны өвс тэжээлийн цэгт 50 тонн хивэг, Бэрх тосгоны өвс тэжээлийн цэгт 100 тонн хивэг нийт 150 тонн хивгийг дотоодын тооцоогоор хүлээн авсан байна.
- B. 2015-08-27 өдрийн тушаалаар №МН/39 150 тонн өвс бэлтгэх эрх олгогдсоны дагуу “Шар тал” өвс тэжээлийн цэгт 150 тонн өвсийг Грийн сийд ХХК-аас бэлтгэн нөөцийг бүрэн бүрдүүлсэн.
- C. Монгол улсын Шадар сайдын 2015 оны 09 сарын 28 өдрийн “Нөөц бүрдүүлэх тухай” 103 тоот тушаалаар “Шар тал” өвс тэжээлийн цэгт 309 тонн үрийн буудайг “Дадал буудай” ХХК-аас худалдан авсан байна.
- D. Монгол улсын Шадар сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайдын хамтарсан “Өвөлжилтийн бэлтгэл хангуулах өр, төлбөр барагдуулах тухай” 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 116/A-129 тоот тушаалаар 100 тонн өвс, 100 тонн хивгийг тус тус агуулах нөхцөлөөр бэлтгэхийг зөвшөөрсөн байна. “Милл хаус” ХХК-аас 100 тонн хивэг, давхардсан тоогоор 18 иргэнээс 2894 боодол буюу 57,9 тонн өвс бэлтгэж, тушаалыг 78,9 хувьтай хэрэгжүүлжээ. Энэ нь иргэдээс ирүүлсэн өвс чанарын шаардлага хангаагүй, зарим иргэд өвсөө өгөөгүй зэргээс шалтгаалсан байна.

1.1.2 Эрх олгогдсон 150 тонн өвсийг бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1, 33 дугаар зүйл заалтыг хэрэгжүүлэн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

- A. Худалдан авах ажиллагаанд “Грийн сийд трейд” ХХК, “Туулайхан” ХХК, “Хангайн ахан дүүс” ХХК компаниудад үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн боловч “Грийн сийд трейд” ХХК, “Туулайхан” ХХК компаниас үнийн санал ирүүлсэн байна.
- B. “Туулайхан” ХХК компаний үнийн санал 1,3 сая төгрөгөөр босго үнэ давсан, тендерийн баримт бичгийн иж бүрдэл хангаагүй тул шалгараагүй байна. Харин “Грийн сийд” ХХК-ний үнийн санал нь босго үнэд багтсан, тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлт хангасан тул шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлж худалдан авалтыг зохион байгуулжээ.
- C. Тендэрт шалгарсан “Грийн сийд” ХХК-ийн үнийн санал босго үнэтэй тэнцүү байсан тул худалдан авах ажиллагаанаас арвилан хэмнэлт гараагүй байна.

1.1.3 Улсын нөөцийн салбарын агуулахад мэргэжлийн хяналтын дүгнэлт гаргуулаагүй байна.

- A. ОБЕГ-ын 03 дугаар нөөцийн салбараас ХБУ-ны өвс тэжээлийн цэгт хүлээж авсан 50 тонн, “Милл хаус” ХХК-аас авсан 100 тн хивэгний хадгалалтын хугацаа 20 хувиас хэтэрсэн байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох” журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.
- B. Улсын нөөцийн тухай хуулийн 17 зүйлийн 17.1.5, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох” журмын 3.3 заалтын дагуу УНС-

ын агуулахын байранд мэргэжлийн хяналтын дүгнэлт гаргуулаагүй байна. Энэ нь нөөцийн бараа, материалыг технологийн дагуу хадгалах нөхцлийг бүрдүүлсэн эсэх, стандарт, эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангаж байгаа эсэх нь тодорхойлох боломжгүй болгож байна.

- С. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2015 оны 04 сарын 15-нд 92,6 тн хорголжин, 112,3 тн улаан буудай, 578,4 тн өвс нь стандартын шаардлага хангаж, ХБУ өвс тэжээлийн цэг дээрх 5,9 тн буюу нийт өвсний 1 хувь “стандарт хангахгүй байна” гэсэн 22/02/010/22 тоот дүгнэлт гаргасан байна. Хуулийн дагуу жилд 1-2 удаа хийгдэх мэргэжлийн хяналтын дүгнэлтийг үндэслэн Улсын нөөцийн барааны шинэчлэлтийг тухай бүрд нь хийдэггүйгээс шалтгаалан стандартын шаардлага хангахгүй бараа материалын үлдэгдэлтэй болсон байна.

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГ ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ:

№	Материалын нэр	Өвс, тэжээлийн цэг	Дүгнэлт гаргуулсан эсэх	Стандарт	Дүгнэлт
1	Хорголжин	ХБУ	Тийм	MNS 1077:2008	Хангасан
2	Хорголжин	Бэрх	Тийм	MNS 1077:2008	Хангасан
3	Өвс 2012 он	ХБУ	Тийм	MNS 592:2008	Хангасан
4	Өвс 2013 он	ХБУ	Тийм	MNS 592:2008	Хангасан
5	Өвс 2012 он	Бэрх	Тийм	MNS 592:2008	Хангасан
6	Өвс 2013 он	Бэрх	Тийм	MNS 592:2008	Хангасан
7	Улаан буудай	Шар тал	Тийм	MNS 097:2010	Хангасан
8	Өвс 2011 он	ХБУ	Тийм	MNS 592:2008	Хангахгүй
9	Өвс 2014 он	ХБУ	Тийм	MNS 592:2008	Хангасан

- D. Тооллого хийж тооцоог бодохдоо хэвийн хорогдлын хувийг тогтоосон хэмжээгээр тооцон, туйлын хэмжүүр болгож ашигладаггүй байна.

Хэвийн хорогдлыг зарим сард тооцоогүй байна.

ХЭВИЙН ХОРОГДОЛ ТООЦСОН ХҮСНЭГТ

№	Огноо	Хивэг	Хорголжин	Өвс	Будаа
1	2015/01/01-01/31	-	12,97	0,14	-
2	2015/02/01-02/28	-	12,94	0,14	-
3	2015/03/01-03/31	-	12,90	0,14	-
4	2015/04/01-04/30	-	12,87	0,16	-
5	2015/05/01-05/31	0,38	0,67	0,16	-
6	2015/06/01-06/30	0,37	0,67	0,16	-
7	2015/07/01-07/31	0,37	-	-	-
8	2015/08/01-08/31	0,37	-	-	-
9	2015/09/01-09/30	0,37	-	-	-
10	2015/10/01-10/31	0,37	-	0,60	-
11	2015/11/01-11/30	0,36	-	0,60	-
12	2015/12/01-12/31	0,61	-	0,72	-
	Нийт	3,18	0,67	6,58	-

1.2 Улсын нөөцийн бараа материалыг шинжилгээнд бүрэн хамруулж мэргэжлийн хяналтын дүгнэлтийг гаргуулсан байна.

1.2.1 Хэнтий аймгийн УНС-т 2015 онд мэргэжлийн хяналтын дүгнэлтийг үндэслэн чанар, стандартын шаардлага хангасан нийт 309 тн үрийн будаа, 207,9 тн өвс, 250 тн хивгийг улсын нөөцөд хүлээж авсан байна.

**ХОЁРДУГААР
БҮЛЭГ**

- **Улсын нөөцийн барааны зарцуулалтын зориулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.**

2.1 Нөөцийн барааг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зарцуулсан боловч зориулалт тодорхойгүй байна.

2.1.1 Хэнтий аймгийн УНС-т 2015 онд дээд байгууллагын шийдвэр ирээгүйн улмаас хуваарилалт хийгдээгүй байна.

2.1.2 Тайлант онд 12,3 сая төгрөгийн өвс, тэжээлийг 100 хувь буюу дансны үнээр, 38,6 сая төгрөгийн будааг 30 хувийн хөнгөлөлттэй үнээр, 4,9 сая төгрөгийн будааг 45 хувийн нэмэгдэлтэй үнээр буюу 55,9 сая төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна.

- А. Зарцуулсан нөөцийн бараанаас 734,4 мянган төгрөгийн хорголжин, 520,0 мянган төгрөгийн хивгэнд зарцуулалт хийх зөвшөөрөл байхгүй байна.
- В. Нийт зарцуулалт нь улсын нөөцөд эргэн төлөгдөх буюу шинэчлэлт хийхээр зарцуулсан, эргэн төлөгдөхгүй буюу буцалтгүй тусламж хэлбэрээр зарцуулсан эсэх нь тодорхойгүй, шинэчлэлт хийсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

2.2 Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

2.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2-д заасны дагуу хөрөнгийн тооллогыг 2015 онд 2 удаа зохион байгуулсан байна.

- А. Эхний хагас жилд нөөцийн бараа материалд тооллого хийх тооллогын комиссыг томилсон тушаал байхгүй боловч ХБУ-ны өвс тэжээлийн цэгт 84,4 сая төгрөг, Бэрх тосгоны өвс тэжээлийн цэгт 70,9 сая төгрөг, Шар талын өвс тэжээлийн цэгт 43,6 сая төгрөгийн нийт 198,9 төгрөгийн бараа материалыг тоолж тооцоо бодсон нь бүртгэл тайлантай тохирч байна.
- В. Сүүлийн хагас жилд хийх хөрөнгийн тооллогын комиссыг УНС-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/33 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Тооллогоор ХБУ-ны өвс тэжээлийн цэгт 89,7 сая төгрөг, Бэрх тосгоны өвс тэжээлийн цэгт 68,7 сая төгрөг, Шар талын өвс тэжээлийн цэгт 327,2 сая төгрөгийн нийт 485,6 төгрөгийн бараа материалыг тоолж тооцоо бодсон нь бүртгэл тайлантай тохирч байна.
- С. Аудитын явцад 2016 оны 05 сарын 2-ны өдрөөр тасалбар болгон Хэрлэн баян улаан, Шар тал, Бэрх тосгоны өвс, тэжээлийн цэгт хяналтын тооллого хийж, тооцоо бодон 2015 оны 12 сарын 31-ний үлдэгдлийг тулган баталгаажуулахад зөрүүгүй таарч тохирсон болно.

2.2.2 2015 оны жилийн эцсийн байдлаар Хэнтий аймгийн УНС-ын балансад 48,6 сая төгрөгийн авлагын бүртгэлтэй байсан ба өр төлбөргүй байна.

- А. Балансад тусгагдсан нийт 48,6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 5 байгууллага хувь хүний 21,7 сая төгрөгийн авлагыг бүртгэл тайлангаас хасаагүй байна.
- В. Шүүхийн шатанд 24,7 сая төгрөгийн авлага, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа 2,1 сая төгрөгийн авлагатай байна

Авлагын дэлгэрэнгүй судалгааг авч үзвэл: /мян.₮/

№	Харилцагчийн нэр	Огноо	Материалын нэр	Мөнгөн дүн	Товч тайлбар
1	М.Чулуунбаатар	2003	Өвс	221,0	Хэрэгсэхгүй болсон
2	"ЖИ Эм" трейд	2004	Будаа	4608,0	Хэрэгсэхгүй болсон
3	"Дорнод Монгол Өлзийт" ХХК	2004	Будаа	11424,0	Хэрэгсэхгүй болсон
4	"Ургац Хүдэр" ХХК	2004	Будаа	5120,0	Хэрэгсэхгүй болсон
5	"Шимт цацал" ХХК	2004	Будаа	2144,0	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа
6	"Өндөрхаан буудай" ХХК	2004	Будаа	303,5	ШШ гарсан, төлбөрийг барагдуулсан
7	Ц.Хуягбаатар, Ж.Нямаа	2014	Өвс, тэжээл	15494,5	Шүүхэд нэхэмжлэл гаргасан
8	Ц.Хуягбаатар, Ж.Нямаа	2015	Тэжээл	9281,2	Шүүхэд нэхэмжлэл гаргасан
9	Милл хаус ХХК	2015	Будаа	0,06	2016 онд төлөгдсөн
	НИЙТ ДҮН			48556,2	

2.2.3 Улсын нөөцийн бараа материалын үлдэгдлийн мэдээ тайланг сар, улирлаар гарган ОБЕГ-ын УНХТГ-т хүргүүлж улирлаар тооцоо нийлж баталгаажуулж ажилласан байна.

- А. Нөөцийн бараа материалын бүртгэлийг анхан шатны баримтаас хөөн шалгахад 2,4 сая төгрөгийн хорголжин тэжээл, 8,0 сая төгрөгийн өвс, нийт 10,4 сая төгрөгийн бараа материалын анхан шатны баримт болох мөнгө тушаасан, бараа материалыг зарлагадсан баримт байхгүй байна. Аудитын явцад УНХТГ-ын мэргэжилтэн, ахлах дэслэгч Д.Мөнхцэцэг төлбөрийн дансанд мөнгө нь орсон тухай жагсаалт гаргаж ирүүлсэн.
- В. Ахлагч Л.Өлзийбаяр, Ж.Амарсанаа, А.Түвшинбаяр, Д.Энхмаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2015 оны 03 сарын 04-ний өдөр Бэрх тосгон дахь өвс тэжээлийн цэгт тооллого хийн, 9,8 сая төгрөгийн дутагдал гарсан тухай протокол үйлдэж баталгаажуулсан боловч өвс тэжээлийн цэгийн нярав гарын үсэг зураагүй, нягтлан бодох бүртгэлд 9,3 сая төгрөгөөр авлага үүсгэсэн нь нягтлан бодох бүртгэлд тооллогын үр дүнг зөрүүтэй тусгасан байна.

**ГУРАВДУГААР
БҮЛЭГ**

• Улсын нөөцөд тавих дотоод хяналт үр дүнгүй байна.

3.1 Улсын нөөцөд тавих дотоодын хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Хэнтий аймаг дахь УНС-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 13-т “Улсын нөөцийн бараа, материалын хадгалалтын чанар, хамгаалалт, борлуулалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар төлөвлөгөө гарган батлуулж мөрдөж ажиллана” гэж тусгасан байна.

- А. Улсын нөөцийн салбарын даргын 2013 оны 11 сарын 05-ны өдрийн Б/32 тушаалаар дотоод хяналтын ажилтныг томилсон байна.
- В. Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан гаргасан байна.
- С. 2015 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Улсын нөөцийн салбарын 2015 онд дотоод хяналт шалгалт хийх 8-н ажил бүхий төлөвлөгөөг УНС-ын даргаар батлуулсан боловч төлөвлөгөөнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, хүрэх үр дүн нь тодорхой бус байна.

3.2 Улсын нөөцөд тавих дотоодын хяналтыг үр нөлөөтэй зохион байгуулаагүй байна.

- А. Төлөвлөгөөний дагуу тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

3.3 Дотоод хяналтаар илрүүлсэн алдаа зөрчлийн талаар ямар нэгэн баримт байхгүй байна

- А. Дотоод хяналтын ажлаар илрүүлсэн алдаа зөрчил, шийдвэрлэсэн тухай ямар нэгэн баримт мэдээ, тайлан байхгүй байна.
- В. Дотоод хяналтын ажлын тайлан гаргасан боловч дотоод хяналтын ажлын төлөвлөгөөтэй уялдаа холбоогүй байна.

Дөрөв. ДҮГНЭЛТ

1. Улсын нөөцийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, стандартын шаардлага хангасан бараа материалаар бүрдүүлсэн байна.
2. Улсын нөөцийн барааны зарцуулалтын зориулалт тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.
3. Дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Улсын нөөцийн салбарын дарга, онцгой байдлын хошууч А.Гантөмөрт:

1. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах
2. Нөөцийн бараа, материалыг хадгалах барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд чанар, стандарт, эрүүл ахуй болон ургамал хорио цээрийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулах
3. Улсын нөөцийн бараа материалыг албан ёсны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн зарцуулалт хийж байх
4. “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэсэн НББ-ийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах
5. Нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдлыг хангах дотоод хяналтын журмыг гаргаж мөрдөх

Улсын нөөцийн салбарын нягтлан бодогч, онцгой байдлын дэслэгч Б.Баттүвшинд:

6. Тооллого тооцоо бодох үед дутагдал гарсан тохиолдолд туйлын хэмжүүр болгон тогтоосон норм хэмжээгээр хэвийн хорогдлыг тооцож, бүртгэл тайланд тусгаж байх
7. Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 5 байгууллага хувь хүний 21,7 сая төгрөгийн авлагыг бүртгэл тайлангаас хасах ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах
8. Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтын дагуу хөтлөж байх

Улсын нөөцийн салбарын агрономич З.Түмэнхүүд:

9. Улсын нөөцөд хадгалалтын хугацаа 20 хувиас хэтрээгүй бараа материалыг хүлээн авч байх.
10. “Нөөцийн бараа, материалын чанарын талаархи мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, тухайн барааны хадгалах хүчинтэй хугацаа зэргийг харгалзан улсын нөөцийн барааны 20 хүртэлх хувийг улирал тутам борлуулж тоо хэмжээ, чанарыг нь бууруулалгүйгээр тухайн бараагаар нь эргүүлэн авах нөхцөлтэйгээр улсын нөөцөөс гаргаж, шинээр нөхөн бүрдүүлнэ” гэсэн журмын заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Зургаа. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


Тайлангийн төслийг аймгийн УНС-ын даргад 2016 оны 5 дугаар сарын 18-нд албан бичгээр хүргүүлж, тайлангын төсөлтэй холбоотой ямар нэг санал ирээгүй тул тайланд өөрчилөлт оруулаагүй болно.


**ХЭНТИЙ АЙМАГ
УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР**
23125 Чингис хот, Хэрлэн сум,
Утас: 70-58-20-90

2016.05.18 № 37.1/40
танай _____ -ны № _____ -г

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Хэнтий аймаг дахь Улсын нөөцийн салбарын 2015 оны улсын нөөцийн барааны санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалтын дагуу гаргасан тайлан зөвлөмжийн талаар санал хүсэлт байхгүй.

ДАРГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХОШУУЧ  А.ГАНТӨМӨР

0039

Долоо. ХАВСРАЛТУУД

1. Улсын нөөцийн барааны үлдэгдлийн баталгаажуулалт болон нэгдсэн судалгаа маягт 1, 2
2. Асуудлын бүртгэл
3. Тайлан баталгаажуулсан тушаал

Судалгаа № 1

УЛСЫН НӨӨЦИЙН БАРААНЫ ҮЛДЭГДЛИЙН ТУЛГАЛТ

/төгрөгөөр/

дд	Ангилал	Үзүүлэлт	2015 онд Санхүүгийн тайлангаар	Тулгалт		
				Тооллого, тооцоо нийлсэн актаар	Аудитын тулгалтаар	Тайлбар
1	Үрийн нөөц	Эхний үлдэгдэл	43,604,883.70		43,604,883.70	
		ДТ гүйлгээ	241,020,000.00		241,020,000.00	
		КТ гүйлгээ	43,604,883.70		43,604,883.70	
		Эцсийн үлдэгдэл	241,020,000.00	241,020,000.00	241,020,000.00	
2	Шатахууны нөөц	Эхний үлдэгдэл				
		ДТ гүйлгээ				
		КТ гүйлгээ				
		Эцсийн үлдэгдэл	=		=	
3	Хүнсний нөөц	Эхний үлдэгдэл				
		ДТ гүйлгээ				
		КТ гүйлгээ				
		Эцсийн үлдэгдэл	=		=	
4	Өвсний нөөц	Эхний үлдэгдэл	98,527,665.00		98,527,665.00	
		ДТ гүйлгээ	50,930,600.00		50,930,600.00	
		КТ гүйлгээ	9,445,545.00		9,445,545.00	
		Эцсийн үлдэгдэл	140,012,720.00	140,012,720.00	140,012,720.00	
5	Тэжээлийн нөөц	Эхний үлдэгдэл	12,340,500.00		12,340,500.00	
		ДТ гүйлгээ	107,054,000.00		107,054,000.00	
		КТ гүйлгээ	14,826,537.00		14,826,537.00	
		Эцсийн үлдэгдэл	104,567,963.00	104,567,963.00	104,567,963.00	
6	Мал	Эхний үлдэгдэл				
		ДТ гүйлгээ				
		КТ гүйлгээ				
		Эцсийн үлдэгдэл	=		=	
7	Бусад/бараа /	Эхний үлдэгдэл				
		ДТ гүйлгээ				
		КТ гүйлгээ				
		Эцсийн үлдэгдэл	=		=	
Нийт дүн		Эхний үлдэгдэл	154,473,048.70		154,473,048.70	
		ДТ гүйлгээ	399,004,600.00		399,004,600.00	
		КТ гүйлгээ	67,876,965.70		67,876,965.70	
		Эцсийн үлдэгдэл	485,600,683.00	485,600,683.00	485,600,683.00	

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер:

Хоёрдахь шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор:

Танилцсан:

УНС-ын дарга, онцгой байдлын хошууч

УНС-ын нягтлан бодогч, онцгой байдлын дэслэгч

Ц ХАТАНБОД

Б.НАРАНЦЭЦЭГ

Ц.ЭНХТҮВШИН

А.ГАНТӨМӨР

Б.БАТТҮВШИН

Судалгаа №2

Төгрөгөөр

УЛСЫН НӨӨЦИЙН БАРААНЧЫ ҮЛДЭГДЛИЙН НЭГДСЭН СУДАЛГАА

Ид	Байршил	Үрхийн нөөц		Шагварууны нөөц		Хүнсний нөөц		Өсөн нөөц		Тэжээлийн нөөц		Мал		Бусад бусад /		Нийт дүн	
		ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН	ТОО ХЭМЖЭЭ	ДҮН
31	Хэлтэй Ой	309 49	241 020 000 00					738 2	140 012 720 0	247 1	104 967 963 0					1 294 3	485 600 663 0

Балтгасан Аудитор
Анхэн шатны хяналт хийсэн аудитын мөнхмөр
Хайрраа шатны хяналт хийсэн Тэргүүлэгч аудитор
Тамгилсан
УНС-ын дарга, онцгой байдалын хашууч
УНС-ын нэгтгэн бодогч, онцгой байдалын дарга

Ц.ХАТАМБОВ
В.НАРАНЦЦЭГ
Э.ЭНХТҮВШИН
А.ГАЛТӨМӨР
В.БАЛТУВШИН

Акулячий бичок

[illegible]

Financial literacy year

Responsible Director

Statistical Analysis

10

© 2001 Blackwell Science Ltd

© 2006 Blackwell Publishing Ltd, *Journal of Internal Medicine* 260: 103–110



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТНИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 14

Өндөрлэлт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
батлах тухай

Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23.2, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан "Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. " Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН

Тайлан бичсэн: Аудитор

Ц.ХАТАНБОЛД

Огноо: 2016.05.20